

**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Нэмэлт хувьцаа гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.1, 62 дугаар зүйлийн 62.1.3 дэх заалт, 87 дугаар зүйлийн 87.1.2 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэний дагуу компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх үүднээс Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн нэг бүр нь 19 төгрөгийн үнэ бүхий 134,953,581 ширхэг, энгийн хувьцааг, хаалттай хүрээнд нэмж гаргасугай.
2. Компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар тогтоосугай.
3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор компанийн нийт зарласан хувьцаа болох 3,003,866,050 ширхэг хувьцаанаас зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан үе шаттайгаар хөрөнгийн зах зээлээс нээлттэй болон хаалттай хүрээнд хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхийг “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд зөвшөөрсүгэй.
4. Нэмэлт хувьцааны санал болгох үнэ, тоо ширхэг, гаргах хэлбэр, хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
5. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хөрөнгө нэмэгдэж, гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт орох тул тус өөрчлөлтийг компанийн дүрэмд тусган холбогдох газруудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлага(Б.Золжаргал)-д тус тус үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

 Ч.ЧИНЗОРИГ